



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2021 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 03

Номгон

Төв, суурин газрын 2021-2022 оны
өвөлжилтийн бэлтгэл хангах тухай

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт ихээр бий болж байгаль, цаг уурын төлөв байдал эрс өөрчлөгдөж байна. Өнгөрсөн жил манай аймгийн хувьд хүн амын дунд цар тахал болсон Ковид-19 халдвар болон мал аж ахуйн салбарт үүссэн ган, зуд гэсэн гамшгийн нөхцөл байдалтай нүүр тулж мэргэжлийн байгууллага, хэлтэс, агентлагуудтай хамтран цаг тухай бүр үр дүнтэй ажил зохион байгуулсанаар харьцангуй хохирол багатай даван туулсан. Энэ жил зун, зуншлага өмнө жилүүдээс сайн болж нийт бэлчээрийн 90 орчим хувь зуншлага сайтай байгаа хэдий ч Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах нарийвчилсан төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны А/526 дугаар захирамжаар батлан хэрэгжилтийг зохион байгуулан ажиллаж байна.

Харин төв суурин газрын хувьд цахилгаан эрчим хүч, дулаан, шугам сүлжээ, зам, гүүр, барилга байгууламж, хот тохижилт, хүн ам зүйн эрүүл мэнд гэх мэт анхаарал хандуулах олон ажил, арга хэмжээ байгаа тул Төв, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор энэхүү албан даалгаврыг хүргүүлж байна.

Нэг. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт Даалгах нь:

1.1. Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга, байгууламж, зам гүүрийг шинээр барих болон арчлалт, засварын ажлуудыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж, ашиглалтад оруулах, он дамжих барилгуудыг хамгаалалтын горимд шилжүүлэх;

Хоёр. Ус, цаг уур, орчны шинжилгээний төвд даалгах нь:

Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлийн богино болон дунд хугацааны урьдчилсан мэдээ, цаг агаарын улирлын урьдчилсан төлөв байдлын талаарх мэдээ, мэдээллээр аж ахуй нэгж, байгууллага, ард иргэдийг тогтмол хангаж ажиллах;

1200110

Гурав. Чандмань-Баянхонгор ХК-д даалгах нь:

- 3.1. Баянхонгор сумын 13-цэцэрлэг, 2-р багийн төв, Гийх наран хорооллын галлагааны зуух, тоног төхөөрөмжийг шинэчлэх;
- 3.2. Баянхонгор сумыг цэвэрлэх байгууламжийн лагийг зайлуулах;
- 3.3. Ус хангамжийн эх үүсвэрт гүний худаг өрөмдөж, барилга барьж, ашиглалтад оруулах;
- 3.4. Ус хангамжийн эх үүсвэрт нөөцийн дизель суурилуулах;
- 3.5. Шинэ суурьшлын бүсийн гадна усан хангамжийн угсралтын ажил хийх;
- 3.6. Бохир усны төв болон салбар шугам сүлжээнд цэвэрлэгээ үйлчилгээ хийх;
- 3.7. Цэвэр усны салбар шугамд тоолуур тавих;

Дөрөв. “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК, Эрчим хүчний зохицуулах зөвлөлд:

- 4.1. Хөх толгой, Полигон фидерийн хүчдэлийг 10кВ хүчдэлийн түвшинд шилжүүлэх;
- 4.2. 110/35/6 кВ-ын "Баянхонгор" дэд станцын 2500 кВАТ-3 трансформаторын хүчин чадлыг 110/10 кВ-ын 10МВА трансформатор болгож нэмэгдүүлэх;
- 4.3. Баянхонгор сумын Рашаант 10 дугаар багт шинээр 35/10кВ-ын 2500кВА хүчин чадалтай ОРУ станц шинээр барих;
- 4.4. Баянхонгор аймгийн нийт дулаан үйлдвэрлэгчдийн өвлийн аваарын нөөц бүрдүүлэлтийг шалгах;
- 4.5. Халаалтын улиралд гэнэтийн аваар саатал гарсан үед гэмтэл устгах болон сэргээн засварлахад анхаарч ажиллах, аваарын нөөц сэлбэг материал бүрдүүлж хангалт хийх;
- 4.6. Угалз 4 дүгээр багийн 1-р гудамжны орчимд хүчдэлийн уналт их байгаа гэр хороололд шинээр 6кВ-ын ЦДАШ, 6/0.4кВ-ын дэд станц шинээр барьж ашиглалтад оруулах;
- 4.7. Цагаанчулуут 5 дугаар багт малтай хороо орчимд хүчдэлийн уналт их байгаа гэр хороололд шинээр 6кВ-ын ЦДАШ, 6/0.4кВ-ын дэд станц шинээр барьж ашиглалтад оруулах;
- 4.8. Бөмбөгөр, Бууцагаан, Галуут сумын 0.4кВ, Өлзийт, Эрдэнэцогт сумын 6кВ, Жаргалант, Гурванбулаг сум, Шаргалжуут тосгоны 10кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын их засварыг тус тус хийж гүйцэтгэх;

4.9. Дулаан үйлдвэрлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд нэг сараас дээш нүүрсний нөөц бүрдүүлж шугам сүлжээний засвар үйлчилгээг хийх;

4.10. Дулаан үйлдвэрлэгч тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниуд агаарын бохирдлыг бууруулахад анхаарах, үнс хог хаягдлыг хадгалах савыг бэлтгэх, сайжруулах;

Тав. Эрүүл мэндийн газарт даалгах нь:

5.1. Нийт хүн амын дунд коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх, тархалтыг хумих төгс арга хэмжээг мэргэжлийн байгууллагуудын оролцоотой зохион байгуулах;

5.2. Ковид-19 цар тахалтай тэмцэх арга хэмжээний хүрээнд эм, урвалж, оношлуур, багаж тоног төхөөрөмж, хүний нөөцийн тасралтгүй байдлыг хангаж нөөц бүрдүүлэлт хийх;

5.3. Өрхийн эрүүл мэндийн төв болон багийн эмч нарын эргэлтийг сайжруулах, алслагдсан бүс нутагт отроор яваа иргэдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, хүртээмжийг нэмэгдүүлэх;

5.4. 0-5 насны хүүхэд, жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настны эрүүл мэндийн хяналтыг эрчимжүүлэх;

5.5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, олон улсын байгууллагын хөрөнгөөр хийгдэж байгаа эрүүл мэндийн барилга байгууламжийн угсралт, их засвар, тохижилтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гэрээний хугацаанд нь хүлээж авах, чанартай хийлгэх;

5.6. Эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийн хана, цонх, хаалга, дээврийн дулаан алдагдлыг бууруулах болон дотоод орчны агаарын чанарыг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах;

Зургаа. Боловсрол, соёл урлагийн газарт даалгах нь:

6.1. Сургууль, цэцэрлэгийн орчмын бүсэд эрсдэлийн үнэлгээ хийж аюулгүй байдлыг хангах арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх;

6.2. Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, талбай, тоглоом наадгай, спортын тоноглол, гадна байрлах нүхэн жорлонд ариутгал, халдваргүйжүүлэлт хийх ажлыг нэгдсэн зохион байгуулалтаар тогтмол хийх, хяналт тавих;

6.3. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгө, олон улсын байгууллагын хөрөнгөөр хийгдэж байгаа цэцэрлэг, сургууль, дотуур байр, спорт заалны барилга угсралт, их засвар, тохижилтын ажлын гүйцэтгэлд хяналт тавих, гэрээний хугацаанд нь хүлээж авах, чанартай хийлгэх;

4.

6.4. Сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжийн хана, цонх, хаалга, дээврийн дулаан алдагдлыг бууруулах болон дотоод орчны агаарын чанарыг сайжруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээг авах;

6.5. Гадна байрлах нүхэн жорлонтой цэцэрлэг, сургуулийг шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болгох ажлыг эрчимжүүлэх;

6.6. Сургууль, цэцэрлэгүүдэд хоол үйлдвэрлэлийн орчин нөхцөлийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах зориулалтын агуулах, зоорийг бий болгох;

6.7. Цэцэрлэг, сургууль, дотуур байранд стандартын шаардлага хангасан цэвэр усны эх үүсвэр, нөөц бий болгох

Долоо. Мэдээлэл холбоо сүлжээ ТӨК-д даалгах нь:

7.1. Мэдээлэл холбоо сүлжээний техникийн үзлэг үйлчилгээний бэлэн байдлыг хангаж ажиллах;

Найм. Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цэвэр хот ОНӨҮГ, Баянхонгор тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГазарт даалгах нь:

8.1. Зам талбайн халтираа гулгааг арилгах тусгай зориулалтын элс, давсыг хангалттай хэмжээнд нөөцөлж, цэвэрлэгээ үйлчилгээнд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийг бэлтгэн хэвийн ажиллагааг хангах;

8.2. Явган замын эвдрэл гэмтлийн засвар үйлчилгээг хийж дуусгах;

8.3. Шинэ суурьшлын бүсийн цөлжилтийг сааруулах, элсний нүүлтээс хамгаалах хамгаалалтын ойн зурвасын хашаа, хамгаалалт, усалгааны систем, намрын тарилтын ажлыг хийж гүйцэтгэх;

8.4. Төв суурин газруудад байгаа ногоон байгууламж, мод, бут сөөгийг эрсдэл багатай өвөлжүүлэх, цэнэг усалгаа, хучилтын ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

Ес. Цагдаагийн газарт даалгах нь:

9.1. Ургац хураалт, хадлан тэжээл болон мал, мах бэлтгэлийн үед төв зам дагуу хяналтын пост тогтмол ажиллуулж, дамжуулан өнгөрүүлэх хяналт шалгалтыг шуурхай зохион байгуулах;

10. Аймгийн Онцгой байдлын газар, Авто тээврийн төвд даалгах нь:

10.1. Цаг уурын хүндрэлтэй байдал үүсэхээс өмнө техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж, замын арчлалт засварын ажлыг дуусгах;

10.2. Үер усны аюулаас үүдэлтэй эвдрэлд орсон орон нутгийн замуудыг сайжруулах ажлыг яаралтай зохион байгуулах;

5.

10.3. Албан даалгаврын хэрэгжилт, өвөлжилтийн бэлтгэл ажилд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд бэлтгэл ажилтай биечлэн танилцаж дүнг Онцгой комиссын хуралд танилцуулахыг Онцгой байдлын газрын дарга, Онцгой байдлын хурандаа /Ж.Алтанбагана/-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН